



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12 нэрийн, нийт 125,024,431.55 (нэг зуун хорин таван сая хорин дөрвөн мянга дөрвөн зуун гучин нэгэн төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 61,017,700.00 (жаран нэгэн сая арван долоон мянга долоон зуун) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Төгөлдөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн  
..... б.д. дугаар тогтоолын хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ,  
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ		
							Цаашид ашиглах жил	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Сандал / дарга OASIS 291 H /	12/16/2013	1	ш	529,900.00	529,900.00	3	250,000.00	250,000.00
2	Зургийн аппарат Nikon D3200	7/5/2015	1	ш	1,045,000.00	1,045,000.00	2	400,000.00	400,000.00
3	Канон скарнертэй 2018	4/20/2008	1	ш	1,653,120.00	1,653,120.00	3	750,000.00	750,000.00
4	Суурин GPS Корс / ком /	12/6/2012	1	ком	29,856,800.05	29,856,800.05	3	15,000,000.00	15,000,000.00
5	2 долгионы GPS Хүлээн авагч / ком	12/16/2016	1	ком	36,016,944.17	58,161,666.00	3	29,100,000.00	29,100,000.00
6	Орон зай хэмжигч BOSH LAZER	12/2/2011	1	ш	450,000.00	450,000.00	3	220,000.00	220,000.00
7	Свич 2014	12/2/2014	1	ш	570,800.00	570,800.00	3	280,000.00	280,000.00
8	Байршил тогтоогч GPS ET-35 Халзан сум	11/2/2017	1	ш	830,000.00	830,000.00	2	230,000.00	230,000.00
9	Эйркондиншн Беко BHVN 180	5/2/2016	1	ш	749,990.00	749,990.00	3	300,000.00	300,000.00
10	Компьютер Dell i7 desktop 2016 Г/харилаа	12/15/2016	1	ш	2,365,000.00	2,365,000.00	1	850,000.00	850,000.00
11	Сервер тогтоох /Рельс /зам/	12/1/2016	1	ш	275400	275400	3	137,700.00	137,700.00
12	Суудлын автомашин /Hyundai Santa EF/, улсын дугаар 51-38 СҮЭ. арлын дугаар KMHSU81CDEU236334	4/13/2015	1	ш	28,536,755.50	28,536,755.50	2	13,500,000.00	13,500,000.00
						<b>125,024,431.55</b>			<b>61,017,700.00</b>
<b>Нийт дүн</b>						(нэг зуун хорин таван сая хорин дөрвөн мянга гучин нэгэн төгрөг тавин таван мөнгө)			(жаран нэгэн сая арван долоон мянга долоон зуу)